

## ТАНИЛЦУУЛГА

Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцид нэгдсэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

Иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдлүүд нь аливаа этгээдийн болон өмчийн аюулгүй байдалд заналхийлж, агаарын харилцаа, нисэх буудлууд, агаарын навигацийн үйлчилгээ, иргэний нисэхийн аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж байгаатай холбогдуулан эдгээр аюул заналаас урьдчилан сэргийлэх, тэмцэх илүү үр дүнтэй арга хэмжээ авахад чиглэсэн олон улсын эрх зүйн хэм хэмжээг бэхжүүлэх зорилгоор 2010 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотноо зохион байгуулсан Нисэхийн аюулгүй байдлын Дипломат бага хурлаас "Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц"-ыг баталсан.

Энэ конвенцид иргэний нисэхийн аюулгүй байдлын олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд дурдаагүй орхигдуулсан зохицуулалтуудыг тодорхой тусгасан бөгөөд Монгол Улс 1972 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр нэгдсэн орсон "Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай" Монреалийн конвенц, түүний нэмэлт Протоколоос давуу хүчин чадалтай олон улсын гэрээ юм.

"Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц" нь 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд 34 улс гарын үсэг зурж, 23 улс соёрхон баталж, 19 улс нэгдэн орж, 1 улс хүлээн зөвшөөрч, 1 улс батлаад байна.

"Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц"-д гэмт хэрэгт тооцох үйлдэл, ялын байдал, гэмт хэргийн оролцогчид, хэргийн харьяалал, гэмт этгээдийг шилжүүлэх, хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг илүү нарийвчлан тусгасан. Тухайлбал, агаарын хөлөг, агаарын навигацийн тоног төхөөрөмжид гэмтэл, аюул учруулах, худал мэдээлэл тараах, ашиглалтад байгаа агаарын хөлгийг хүний амь нас хохироох, эрүүл мэнд, өмч хөрөнгө, хүрээлэн буй орчинд үлэмж хохирол учруулахад ашиглах, биологийн, химийн, цөмийн аливаа зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт, тэдгээртэй адилтгах зүйлийг агаарын хөлгөөс цацах, хаях, тээвэрлэх, олон улсын иргэний нисэх буудлын хэвийн горимыг алдагдуулж, аюулгүй байдалд нөлөөлөх, эдгээр төрлийн хууль бус үйлдлийн оролдлого хийх, заналхийлэх, үйлдэхэд дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах, удирдах, үгсэн хуйвалдах зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор тусгасан байна.

Монгол Улс Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн улсын хувьд тус байгууллагын бодлого, зорилтыг дэмжих, хэрэгжүүлэх, иргэний нисэхийг хөгжүүлэх бодлогын хүрээнд олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох үүрэгтэй.

Манай улсын нутаг дэвсгэр дээгүүр үйлдэж буй нислэгийн тоо жилээс жилд өсч, нислэгийн чиглэл нэмэгдэж, агаарын харилцаа өргөжин хөгжиж байгаа энэ үед иргэний нисэхийн аюулгүй байдлын эрх зүйн тогтолцоог сайжруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Иймд Монгол Улсын иргэний нисэхийн салбарын аюулгүй байдлын стандартын түвшинг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх, иргэний нисэхийн эсрэг хууль

бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариуцлага хүлээлгэх олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн хэм хэмжээг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор "Олон Улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц"-д нэгдэн орох шаардлагатай байгаа болно.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасны дагуу дээрх конвенцыг Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар байгаа тул "Олон Улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц"-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

"Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц"-ын 1 дүгээр зүйлд гэмт хэрэгт тооцох үйлдлүүдийг заасан бол 3 дугаар зүйлд 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт хүнд ял оногдуулах үүрэг хүлээхээр тусгасан байдаг. Үүнтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 27 дугаар бүлэгт зарим зүйл, хэсэг нэмэх, өөрчлөлт оруулахаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР